



# ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2016 оны 12 дугаар сар


**Ерөнхий тойм:** Энэ оны эхний 12 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 2.3%-иар буюу 191.5 сая ам.доллараар буурч 8275.3 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 5.3%-иар буюу 248.1 сая ам.доллараар өссөн хэдий ч импорт 11.6%-иар буюу 439.6 сая ам.доллараар буурсан нь нөлөөлжээ. Тайлант хугацаанд экспортын дүн импортын дүнгээс 1559.4 сая ам.доллараар давж гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 687.6 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.

**Хүснэгт 1.** Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 12 сараар			Өөрчлөлт			
	2013	2014	2015	2014/2013		2015/2014		2014	2015	2016	2015/2014		2016/2015	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	10,627	11,011	8,467	384	3.6%	(2,544)	-23.1%	11,011	8,467	8,275	(2,544)	-23.1%	(192)	-2.3%
Экспорт	4,269	5,774	4,669	1505	35.3%	(1,105)	-19.1%	5,774	4,669	4,917	(1,105)	-19.1%	248	5.3%
Импорт	6,358	5,237	3,798	(1,121)	-17.6%	(1,439)	-27.5%	5,237	3,798	3,358	(1,439)	-27.5%	(440)	-11.6%
Тэнцэл	(2,089)	538	872	2,626		334	62.1%	538	872	1,559	334		688	78.9%

**Валютын төлбөртэй худалдааны тэнцэл** нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид нөлөөлдөг суурь хүчин зүйлүүдийн нэг юм. Валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2016 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр 1619.8 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 435.4 сая ам.доллараар өссөн байна.

**Зураг 1.** Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




**Зураг 2.** Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



**Хөрш орнуудтай хийсэн худалдааг** авч үзвэл, нийт бараа эргэлтийн 59.5% буюу 4923.4 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 11.3% буюу 936.2 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 6.4%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 14.7%-иар тус тус буурсан байна.

**Зураг 3.** Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



**Хүснэгт 2.** Худалдааны нөхцөлийн индекс /2012 оны 12 сар суурьтай/

Үнийн индексийн төрөл*	2015.12 сар	2016.11 сар	2016.12 сар	Жил Δ	Сар Δ
<b>Экспорт</b>	<b>0.75</b>	<b>0.78</b>	<b>0.85</b>	<b>14%</b>	<b>8%</b>
Зэсийн баяж мал	0.34	0.31	0.34	1%	9.5%
Чулуун нүүрс	0.39	0.51	0.56	44%	10.8%
Ямааны угаасан ноолуур	0.40	0.33	0.34	-16%	3.6%
<b>Импорт</b>	<b>0.63</b>	<b>0.52</b>	<b>0.55</b>	<b>-13%</b>	<b>6%</b>
Хэрэглээний бараа	0.81	0.74	0.72	-11%	-3%
Хөрөнгө оруулалтын бараа	0.59	0.38	0.48	-18%	25%
Нефтийн бүтээгдэхүүн	0.49	0.49	0.49	0%	-2%
<b>Худалдааны нөхцөл</b>	<b>1.19</b>	<b>1.51</b>	<b>1.55</b>	<b>30%</b>	<b>3%</b>

\* Индексийн өөрчлөлтөд голлох хувь нэмэр оруулсан бараагаар задлав.

**Гадаад худалдааны нөхцөлийн индекс** тайлант хугацааны эцэст өмнөх оны мөн үеэс 30.5%-иар, өмнөх сараас 2.5%-иар өсч 1.551-д хүрлээ. Тайлант сард нефтийн бүтээгдэхүүний импортын үнэ буурсан, нүүрс, зэсийн экспортын үнэ өссөнөөс худалдааны нөхцөл өмнөх сараас сайжирсан байна.

Экспорт 2016 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 5.3%-иар буюу 248.1 сая ам.доллараар өссөн. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын өсөлт нь нийт экспортыг 2.6 нэгж хувиар, уул уурхайн түүхий эдийн экспортын өсөлт нь нийт экспортыг 3.1 нэгж хувиар тус тус өсөхөд нөлөөлжээ. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 1.5 нэгж хувиар буурсан бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний жин 2.2 нэгж хувиар өссөн байна.

**Хүснэгт 3. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/**

Төрөл	2014			2015			2016			Δ (2015/2014)			Δ (2016/2015)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% <sup>2</sup>	Дүн	Өсөлт	% <sup>2</sup>
<b>1. Уул уурхай</b>		<b>5,184</b>	<b>90%</b>		<b>4,092</b>	<b>88%</b>		<b>4,238</b>	<b>86%</b>	<b>(1,092)</b>	<b>-21%</b>	<b>-19%</b>	<b>146</b>	<b>4%</b>	<b>3.1%</b>
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	1,378	2,574	45%	1,478	2,280	49%	1,554	1,606	33%	(293)	-11%	-5%	(674)	-30%	-14%
1.2. Чулуун нүүрс	19,480	849	15%	14,426	555	12%	25,607	968	20%	(294)	-35%	-5%	413	74%	9%
1.3. Боловсруулаагүй нефть	6,885	635	11%	8,135	387	8%	7,977	336	7%	(247)	-39%	-4%	(52)	-13%	-1%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	6,324	446	8%	5,065	227	5%	6,425	261	5%	(219)	-49%	-4%	33	15%	7%
1.5. Мөнгөжөөг үйл /кг/	10,041	405	7%	11,343	421	9%	19,169	758	15%	15	4%	0%	338	80%	7%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	99	113	2%	84	102	2%	126	144	3%	(12)	-10%	0%	42	41%	1%
1.7. Жош, лейцит, нефелинт	314	72	1%	280	65	1%	247	59	1%	(6)	-8%	0%	(7)	-10%	0%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	4	36	1%	5	29	1%	6	26	1%	(6)	-17%	0%	(3)	-10%	0%
1.9. Гянт болдын хүдэр, баяжмал	2	20	0%	2	14	0%	1	10	0%	(6)	-30%	0%	(4)	-26%	0%
1.10. Мөнгө /тонн/	42	33	1%	54	10	0%	95	39	1%	(22)	0%	0%	29	278%	1%
1.11. Бусад	18	3	0%	53	2	0%	133	31	1%	(1)	-42%	0%	30	7%	1%
<b>2. Мал аж, ахуй</b>		<b>361</b>	<b>6%</b>		<b>329</b>	<b>7%</b>		<b>316</b>	<b>6%</b>	<b>(32)</b>	<b>-9%</b>	<b>-1%</b>	<b>(13)</b>	<b>-4%</b>	<b>-0.3%</b>
2.1. Амьд мал, малын мах	3	7	0%	5	14	0%	9	19	0%	6	88%	0%	5	37%	0%
2.2. Арьс, шир	298	36	1%	340	33	1%	173	24	0%	(3)	-8%	0%	(9)	-26%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	8	0%	0	9	0%	0	7	0%	1	10%	0%	(2)	-26%	0%
2.4. Ноолуур	7	294	5%	7	252	5%	7	242	5%	(42)	-14%	-1%	(10)	-4%	0%
2.5. Ноос, бусад үс, хялгас	9	15	0%	14	21	0%	16	22	0%	6	36%	0%	1	5%	0%
2.6. Бусад	0	0	0%	0	1	0%	1	2	0%	0	140%	0%	1	242%	0%
<b>3. Газар тариалан</b>		<b>29</b>	<b>0%</b>		<b>27</b>	<b>1%</b>		<b>24</b>	<b>0%</b>	<b>(2)</b>	<b>-5%</b>	<b>0%</b>	<b>(3)</b>	<b>-12%</b>	<b>-0.1%</b>
<b>4. Аж үйлдвэрлэл</b>		<b>199</b>	<b>3%</b>		<b>219</b>	<b>5%</b>		<b>338</b>	<b>7%</b>	<b>20</b>	<b>10%</b>	<b>0%</b>	<b>119</b>	<b>55%</b>	<b>2.6%</b>
4.1. Хүнс	1	6	0%	4	26	1%	9	43	1%	20	357%	0%	17	67%	0%
4.2. Ноолууран эдлэл	1	24	0%	1	25	1%	1	26	1%	1	4%	0%	1	3%	0%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	1	8	0%	1	10	0%	2	20	0%	2	25%	0%	9	94%	0%
4.4. Уул уурхай	20	58	1%	35	78	2%	31	88	2%	21	36%	0%	9	12%	0%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	4	0%	0	4	0%	0	5	0%	(0)	-6%	0%	1	25%	0%
4.6. Машиин механик, тоног төхөөрөмж, эд анги	2	92	2%	1	70	1%	1	149	3%	(22)	-24%	0%	79	114%	2%
4.7. Бусад	192	8	0%	185	6	0%	237	8	0%	(2)	-21%	0%	2	36%	0%
<b>5. Бусад</b>		<b>2</b>	<b>0%</b>		<b>2</b>	<b>0%</b>		<b>1</b>	<b>0%</b>	<b>(0)</b>	<b>-5%</b>	<b>0%</b>	<b>(1)</b>	<b>-59%</b>	<b>0.0%</b>
<b>Нийт дүн</b>		<b>5,774</b>		<b>4,669</b>			<b>4,917</b>			<b>(1,105)</b>	<b>-19%</b>		<b>248.1</b>	<b>5.3%</b>	


%<sup>2</sup> - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

**Хүснэгт 4. Экспортын өөрчлөлт, 2016 он**

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
<b>1. Уул уурхай</b>	<b>936.9</b>		<b>(790.8)</b>		<b>146.1</b>	<b>4%</b>
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	78.9	-12%	(752.7)	112%	(673.7)	-30%
1.2. Чулуун нүүрс	422.7	102%	(9.6)	-2%	413.2	74%
1.3. Боловсруулаагүй нефть	(6.7)	13%	(45.0)	87%	(51.6)	-13%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	55.2	165%	(21.8)	-65%	33.4	15%
1.5. Мөнгөжөөг үйл /кг/	309.6	92%	28.2	8%	337.8	80%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	47.7	114%	(5.8)	-14%	41.9	41%
1.7. Жош, лейцит, нефелинт	(7.7)	112%	0.9	-12%	(6.8)	-10%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	3.5	-14%	(6.5)	214%	(3.0)	-10%
1.9. Гянт болдын хүдэр, баяжмал	(2.2)	60%	(1.4)	40%	(3.6)	-26%
1.10. Мөнгө /тонн/	16.9	59%	11.9	41%	28.8	278%
1.11. Бусад	18.9	63%	10.9	37%	29.7	0%
<b>2. Мал аж, ахуй</b>	<b>4.0</b>	<b>-31%</b>	<b>(16.9)</b>	<b>131%</b>	<b>(12.9)</b>	<b>-4%</b>
2.2. Арьс, шир	(23.1)	270%	14.5	-170%	(8.6)	-26%
2.4. Ноолуур	12.9	-134%	(22.4)	234%	(9.6)	-4%
<b>3. Газар тариалан</b>	<b>2.5</b>	<b>-77%</b>	<b>(5.7)</b>	<b>177%</b>	<b>(3.2)</b>	<b>-12%</b>
<b>4. Аж үйлдвэрлэл</b>	<b>21.6</b>	<b>18%</b>	<b>97.8</b>	<b>82%</b>	<b>119.4</b>	<b>55%</b>
<b>5. Бусад</b>	<b>(0.4)</b>	<b>27%</b>	<b>(1.0)</b>	<b>73%</b>	<b>(1.3)</b>	<b>-59%</b>
<b>Нийт дүн</b>	<b>964.6</b>		<b>(716.5)</b>		<b>248.1</b>	<b>5%</b>

\* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

**Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ**



2016 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр экспортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 964.6 сая ам.доллараар өссөн бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 716.5 сая ам.доллараар буурсан байна. Мал аж, ахуйн түүхий эдийн экспорт үнэ буурснаас голлон шалтгаалж 12.9 сая ам.доллараар буурсан байна. Харин машин, тоног төхөөрөмжийн экспортын өсөлтөөс голлон шалтгаалж аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт 55%-иар буюу 119.4 сая ам.доллараар өсчээ.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2016 оны 12 дугаар сард 1,150 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 7.7%-иар өссөн бол өнгөрсөн сараас 6.7%-иар буурчээ. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн үнэ тайлант сард харгалзан 5,660, 80 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 22%-иар, төмрийн хүдэр 97%-иар, өнгөрсөн сартай харьцуулахад харгалзан 4%, 10%-иар тус тус өссөн байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 12 дугаар сард 55 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 87.0%-иар, өмнөх сараас 13.2%-иар тус тус нэмэгдэв.

Импорт 2016 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 11.6%-иар буюу 439.6 сая ам.доллараар буурсан. Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 8 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 5 нэгж хувийг тус тус тайлбарлаж байна. Хэрэглээний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 6 нэгж хувиар өссөн бол нефтийн бүтээгдэхүүний жин 3 нэгж хувиар буурчээ.

**Хүснэгт 5.** Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2014			2015			2016			Δ (2015/2014)			Δ (2016/2015)			
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%²	Дүн	Өсөлт	%²	
<b>Хэрэглээний бүтээгдэхүүн</b>		<b>1,379</b>	<b>26%</b>		<b>1,101</b>	<b>29%</b>		<b>1,159</b>	<b>35%</b>		<b>(278)</b>	<b>-20%</b>	<b>-5%</b>	<b>58</b>	<b>5%</b>	<b>2%</b>
Түргэн эдэлгээтэй	897	764	15%	836	643	17%	823	652	19%	(121)	-16%	-2%	9	1%	0%	
Хүнс	413	531	10%	377	445	12%	394	453	13%	(87)	-16%	-2%	8	2%	0%	
Эм, пүриа	3	82	2%	2	75	2%	2	90	3%	(7)	-8%	0%	16	21%	0%	
Бусад түргэн эдэлгээтэй бараа	481	151	3%	456	123	3%	427	109	3%	(27)	-18%	-1%	(15)	-12%	0%	
Удаан эдэлгээтэй	165	615	12%	167	459	12%	125	507	15%	(157)	-25%	-3%	49	11%	7%	
Гуул, хувцас, цүнх	36	58	1%	44	49	1%	44	53	2%	(9)	-15%	0%	4	8%	0%	
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба твилга	60	137	3%	69	94	2%	24	97	3%	(43)	-32%	-1%	3	3%	0%	
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	2	348	7%	1	254	7%	1	294	9%	(94)	-27%	-2%	41	16%	7%	
Бусад удаан эдэлгээтэй бараа	68	73	1%	53	62	2%	56	63	2%	(11)	-15%	0%	1	2%	0%	
<b>Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн</b>		<b>2,098</b>	<b>40%</b>		<b>1,447</b>	<b>38%</b>		<b>1,152</b>	<b>34%</b>		<b>(650)</b>	<b>-31%</b>	<b>-12%</b>	<b>(295)</b>	<b>-20%</b>	<b>-8%</b>
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	23	1,114	21%	19	757	20%	17	684	20%	(357)	-32%	-7%	(72)	-10%	-2%	
Суудлаас бусад твэрийн хэрэгсэл, эд анги	1	281	5%	1	113	3%	1	214	6%	(169)	-60%	-3%	101	90%	3%	
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	23	832	16%	18	644	17%	16	471	14%	(188)	-23%	-4%	(173)	-27%	-5%	
Барилгын материал	2,682	756	14%	1,638	473	12%	691	283	8%	(284)	-38%	-5%	(190)	-40%	-5%	
Хөрөнгө оруулалтын бусад бараа	107	228	4%	78	218	6%	53	185	6%	(10)	-4%	0%	(33)	-15%	-1%	
<b>Аж үйлдвэрлэлийн орц</b>		<b>591</b>	<b>11%</b>		<b>512</b>	<b>13%</b>		<b>508</b>	<b>15%</b>		<b>(79)</b>	<b>-13%</b>	<b>-2%</b>	<b>(4)</b>	<b>-1%</b>	<b>0%</b>
Хүнсний орц	60	32	1%	51	28	1%	191	53	2%	(4)	-12%	0%	25	88%	1%	
Химийн бүтээгдэхүүн	123	93	2%	128	89	2%	129	86	3%	(4)	-4%	0%	(3)	-4%	0%	
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	30	17	0%	19	16	0%	28	19	1%	(0)	-3%	0%	3	16%	0%	
Цахилгаан эрчим хүч	1	130	2%	1	129	3%	1	124	4%	(1)	-1%	0%	(5)	-4%	0%	
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	1	0	0%	0	1	0%	2	1	0%	1	212%	0%	(0)	-5%	0%	
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалт ат	871	319	6%	762	248	7%	752	225	7%	(71)	-22%	-1%	(23)	-9%	-1%	
<b>Нефтийн бүтээгдэхүүн</b>		<b>1,148</b>	<b>22%</b>		<b>1,146</b>	<b>19%</b>		<b>1,060</b>	<b>16%</b>		<b>(447)</b>	<b>-39%</b>	<b>-9%</b>	<b>(174)</b>	<b>-25%</b>	<b>-5%</b>
Дизель түнш	686	656	13%	655	377	10%	554	257	8%	(280)	-43%	-5%	(119)	-32%	-3%	
АИ-92, АИ-95	309	320	6%	361	228	6%	330	165	5%	(92)	-29%	-2%	(63)	-28%	-2%	
А-80 болон бусад	153	178	3%	131	103	3%	176	111	3%	(76)	-42%	-1%	8	8%	0%	
<b>Бусад</b>		<b>12</b>	<b>0%</b>		<b>20</b>	<b>1%</b>		<b>124</b>	<b>0%</b>		<b>16</b>	<b>0%</b>		<b>(23)</b>	<b>-1%</b>	
<b>Нийт дүн</b>		<b>5,237</b>			<b>3,798</b>			<b>3,358</b>			<b>(1,439)</b>	<b>-27.5%</b>		<b>(439.6)</b>	<b>-11.6%</b>	

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

**Хүснэгт 6.** Импортын өөрчлөлт, 2016 он

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
<b>Хэрэглээний бүтээгдэхүүн</b>	<b>19.4</b>	<b>34%</b>	<b>38.3</b>	<b>66%</b>	<b>57.7</b>	<b>5%</b>
Түргэн эдэлгээтэй	9.0	99%	0.1	1%	9.0	1%
Удаан эдэлгээтэй	10.4	21%	38.3	79%	48.7	11%
<b>Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн</b>	<b>(271.0)</b>	<b>92%</b>	<b>(24.5)</b>	<b>8%</b>	<b>(295.4)</b>	<b>-20%</b>
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	(96.9)	134%	24.4	-34%	(72.5)	-10%
Барилгын материал	(167.7)	88%	(22.3)	12%	(190.0)	-40%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	(6.4)	19%	(26.6)	81%	(33.0)	-15%
<b>Аж үйлдвэрлэлийн орц</b>	<b>44.6</b>		<b>(48.9)</b>		<b>(4.3)</b>	<b>-1%</b>
<b>Нефтийн бүтээгдэхүүн</b>	<b>(33.6)</b>	<b>19%</b>	<b>(140.6)</b>	<b>81%</b>	<b>(174.2)</b>	<b>-25%</b>
Дизель түнш	(47.0)	39%	(72.5)	61%	(119.4)	-32%
АИ-92, АИ-95	(15.1)	24%	(48.0)	76%	(63.1)	-28%
А-80 болон бусад	28.4	339%	(20.1)	-239%	8.4	8%
<b>Бусад</b>	<b>5.0</b>	<b>-21%</b>	<b>(28.4)</b>	<b>121%</b>	<b>(23.4)</b>	<b>0%</b>
<b>Нийт дүн</b>	<b>(235.5)</b>	<b>54%</b>	<b>(204.1)</b>	<b>46%</b>	<b>(440)</b>	<b>-12%</b>

\* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

**Зураг 5.** Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2016 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр импорт тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 236 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 204 сая ам.доллараар тус тус буурчээ. Хэрэглээний бүтээгдэхүүний импортын тоо хэмжээ, үнэ нэмэгдсэнээс шалтгаалан уг бүлгийн импорт 57.7 сая ам.доллараар өсчээ. Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 20%-иар буурсан нь уг бүлгийн импортын тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

Харин нефтийн бүтээгдэхүүний импорт 25%-иар буурчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2013 оноос эхлэн үргэлжлэн буурч байсан хэдий ч 2016 оны 12 дугаар сарын байдлаар тонн тутамд 546.1 ам.долларт хүрч 3 сар дараалан өсөөд байна.